

Гутгаар байрын бүтээл:

## **ХУВЬ ХҮНИЙ САНХҮҮГИЙН СОЁЛ БА УЛСЫН ХӨГЖИЛ**

Оролцогч:

Н.Амартүвшин, санхүүгийн зөвлөх

Тэртээ 30-аад жилийн өмнө Монголчууд бид нийгэм, эдийн засгийн эрх чөлөөгөө гартаа атгаж Чөлөөт зах зээлийн системээр замнах болсноор багагүй хугацаа өнгөрчээ. Хуучин ЗХУ-ын тусламж, зээлээр бүхнээ шийддэг байсан үе ард хоцорч Монголчууд бид улс орон, өрх гэрийнхээ хувь заяаны хүрдийг тэр үеэс бие даан залуурдах боллоо. Шилжилтийн хүнд хэцүү үеийг улс орноороо хамтдаа харьцангуй амжилттай даван туулж байгаа хэдий ч өөрчлөлт шинэчлэлтийн хурдыг гүйцэхгүй хоцрогдож байгаа хувь хүнээс шалтгаалсан зүйлсийн нэг нь өрхийн төсөв, хувь хүний санхүүгийн соёл гэдэг нь сүүлийн үед илт анзаарагдаж байна

Өнөөгийн Монголын нийгэмд хувь хүний санхүү болон өрхийн төсвийн тухай яриа эхлэхээр “...цалин хүрдэггүй”, “...мөнгө байхгүй”, “...өр зээлд баригдсан” гэх мэтийн нийтлэг, жижүүрийн хариултууд улиг болтлоо газар авч бид ч өөрсдөө “бусдаас бурууг хайх” энэ хандлагадаа хайрцаглагджээ. Мэдээж тодорхой хэмжээнд өрх гэр, хувь хүний санхүүгийн байдал нь улс орны мөнгө төсвийн бяр чадалтай холбоотой л доо, гэхдээ үнэхээр бидний ойлгодог шиг ийм гүн холбоотой гэж үү.

Хувь хүний санхүүгийн талаар судлаад үзвэл улс орны эдийн засаг, санхүүгийн хүч чадал нь иргэдийн санхүүгийн өндөр сахилга бат, хариуцлагатай шууд холбоотой гэдэг нь тодорхой болно. Тиймээс иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлж сахилга батыг сайжруулах нь бидний төсөөлж байгаагаас илүү эерэг ач холбогдолтой. Ингэхийн тулд хувь хүний санхүүгийн мэдлэгт чухал нөлөөтэй нэн тэргүүний 3 асуудлыг хөндлөө

### **1. ӨРХИЙН ТӨСВИЙН САХИЛГА БАТАА САЙЖРУУЛАХ**

2018 оны байдлаар Монгол улсын өрхийн дундаж орлого 1.1 сая төгрөг байгаа бол өрхийн зардал 1.2 сая төгрөг байна гэсэн судалгаа гарчээ. Өөрөөр хэлбэл бид олсноосоо ихийг зарж байгаа энэхүү буруу тогтолцоо нь айл өрхийн, цаашлаад улс орны санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлөх үндэс болж байна. Олсноосоо ихийг

үрэх нь ёроолгүй хувинд ус хийхтэй адил тул өрхийн төсвийн сахилга батаа дээшлүүлэх нь хүн бүрийн өөртөө хэвшүүлэх нэн тэргүүний соёл, дадал юм. Дэлхий дахин тогтвортой хөгжлийн замаар замнаж буй энэ үед минималист амьдра лын хэв маяг тренд болж байгааг анзаарч цаг үеэсээ хоцрохгүй байхаа бодсон ч тэр, “Адууныхаа хирээр исгэрч, хөнжлийнхөө хирээр хөлөө жий” гэдэг ардын зүйр цэцэн үгээ санасан ч тэр бид олж байгаагаа өнөөдрийн хэрэгцээндээ хүргэж цаашилбал урьдчилж хуримтлуулж амьдрах учиртай. Тэгвэл өрхийн төсвийн сахилга батаа хэрхэн сайжруулах вэ? Нийтлэг 3 жишээ татан тайлбарлахыг хичээвэл:

- *Өрхийн орлого зардлаа хөтлөх*

Хэдийг олж хэдийг зарж байгаагаа мэдэхгүй байх нь задгай далайд залуургүй завьтай аялахтай адил. Тиймээс өдөр бүр орлого зардлаа бүртгэж хэвших нь хамгийн эхний алхам. Цаашлаад үр хүүхдэдээ ч зааж сурган санхүүгийн боловсрол олгох боломж юм. Бүртгэх аргын тухайд технологийн дэвшлийг ашиглан гар утасны аппликейшн ашиглахаас эхлээд уламжлалт арга болох өдөр бүр гараар бичиж хөтөлсөн ч болно.

- *Хүсэл, хэрэгцээ хоёроо ялгаж*

Ам цангасан үед дэлгүүрээс ус авч уух нь хэрэгцээ. Харин хажуугийн кофе шопт орж кофе уух нь хүсэл. Ус авч уухад 500 төгрөг зарцуулах бол кофе уухад 8500 төгрөг зарцуулна. Хүслээ байнга дагавал санхүүд маш хохиролтой гэдэг нь тодорхой. Тиймээс хүсэл хэрэгцээ 2-ын аль нь чухал вэ гэдгээ ялгаж салгаж санхүүгийн шийдвэр гаргах нь зөв.

- *Эрүүл мэнддээ анхаарах*

Сонирхолтой нь эрүүл мэнд, хувийн санхүү хоёр хоорондоо салшгүй уялдаатай. Хотын түгжрэл дунд автомашин унаж бензин шатааж сууснаас ажилдаа алхаж явах нь цаг, мөнгөө хэмнэхээс гадна эрүүл мэндэд эерэгээр нөлөөлнө. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн өвдөхөд өрхийн санхүүд асар их хохиролтой. Эрүүл амьдрах дадал хэвшил бүр нь өрхийн санхүүг тэр чинээгээр хэмнэж байдаг.

## **2. ХУРИМТЛАЛЫН СЭТГЭЛГЭЭТЭЙ БОЛОХ**

Бүгд жигдхэн цалин, жигд амьдралтай байсан өмнөх нийгэмтэй холбоотой ч юм уу, эсвэл материаллаг хэрэгцээ багатай нүүдэлчдийн сэтгэхүйн онцлог ч юм уу өнөөдөртөө болж байвал маргааш яах нь хамаагүй мэт үрэлгэн хандах задгай сэтгэлгээ өнөөдөр бидэн дунд давамгайлж байна. Монгол улсын хэмжээнд нийт өрхийн 76% нь хадгаламжгүй гэдгийг Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018”-д дурджээ.

Хуримтлалтай иргэн, айл өрхүүд нь санхүүгийн асуудал тулгарахад дарамт багатайгаар шийдэх боломжтойгоос гадна сэтгэлзүйн хувьд тайван, стресс багатай, ирээдүйдээ итгэлтэй байдлыг бий болгож байдаг. Тэр утгаараа хуримтлалтай байх нь зөвхөн эдийн засгийн хувьд төдийгүй нийгмийн ач холбогдол ихтэй байдаг тул өрх айл бүр дор бүрнээ хуримтлалыг амьдралын нэг хэвшил болгох нь туйлын чухал байна.

- *“Зайлшгүй хуримтлуулах” сэтгэлгээг өрх айл, хувь хүн бүр өөртөө суулгах*

Өнөөдөр Монгол өрхүүд хуримтлалгүйгээс болоод том, жижиг санхүүгийн асуудал тулгарах үед зээлээр шийддэг буруу хэвшил тогтож байна. Сар болгон банкны зээлэнд сарын цалингийнхаа 50-60%-г төлөөд байж чаддаг хирнээ хуримтлалдаа тодорхой хэмжээний мөнгө зарцуулж чадахгүй байгаа нь санхүүгийн гэхээсээ илүү сэтгэлзүйн асуудал байгааг илэрхийлж байгаа хэрэг. Үүнийг өөрчилж хуримтлалын ач холбогдлыг ухамсарлаж зайлшгүй энэхүү соёлыг төлөвшүүлэх нь хувь хүн, айл өрх бүрийн санхүүгийн үүрэг юм.

- *Хүүхдийн боловсролд зориулах хуримтлал үүсгэх*

Хүүхэд, залууст чанартай боловсрол эзэмшүүлэх нь наанадаж эцэг эхийн үүрэг. Бүр цаашлаад улс орны урт хугацааны тогтвортой хөгжлийн үндэс суурь юм. Боловсролд зориулсан хөрөнгө оруулалт нь дэлхий дээр хамгийн өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын төрөлд тооцогддог аж. Тиймээс эцэг эхчүүд бид хүүхдийн ирээдүйн боловсрол, хөгжилд нь зориулж хуримтлал үүсгэх маш чухал гэдгийг ухамсарлаж одооноос бэлтгэж байх хэрэгтэй.

- *Тэтгэвэрт гарах үед зарцуулах хуримтлал үүсгэх*

Манай улсын тэтгэврийн тогтолцооны онцлог, улс орны санхүүгийн тамир тэнхээтэй холбоотойгоор тэтгэвэрт гарсан хүмүүс маань харьцангуй бага орлогоор амьдрах хүндхэн асуудал тулгардаг нь нууц биш. Гэтэл бид өнөөдрөөс эхэлж өөрсдөө ирээдүйдээ санаа тавьж тэтгэврийн хуримтлалыг үүсгэх тал дээр юу хийж байна вэ? Тэтгэвэрт гарах бэлтгэл, түүнд зориулсан хуримтлал гэдэг нь бусад улс хувийн санхүүгийн салбар шинжлэх ухааны түвшинд хүртэл хөгжиж байна. Өндөр хөгжилтэй орны иргэд тэтгэвэрт гарахаараа гадаад улс орнуудаар аялж зугаалж явахад Монгол хөгшчүүд тэтгэврийн хэдэн төгрөгөө хүргэх гэж чадан ядан амьдрах сайхан гэж үү?

Бид харин яг одоо эхлэхгүй бол хоцрох нь, өөрсдөө эхэлье, хуримтлуулъя.

### **3. ӨР ЗЭЭЛИЙН БУРУУ ДАДАЛ ХЭВШИЛ**

Монгол улсад банкны систем хурдацтай хөгжиж улс орны өнцөг булан бүрт салбар нэгжээ нээн санхүүгийн зуучлалын үүргээ амжилттай гүйцэтгэж байна. Сүүлийн жилүүдэд ББСБ, ломбард гэх мэт бусад зээлдүүлэгч нар ч олширчээ. Сайн талаас нь харвал мөнгө зээл олдоцтой, хөгжилд тустай нь гарцаагүй боловч санхүүгийн сахилга бат, соёлд төдийлөн суралцаагүй иргэдийн хувьд өрийн хэт дарамтад орох зэрэг сөрөг нөлөөлөл ч бас давхар илэрч байна.

“Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2018”-ыг сөхөж харвал манай улсын нийт өрхүүдийн 55% нь банкны зээлтэй бөгөөд банкны зээлэнд сар бүр дунджаар 508,000 төгрөг төлдөг гэжээ. ББСБ, ломбард зэрэг бусад зээлдүүлэгч нарыг оруулж тооцвол манай улсын өрхүүдийн хамгийн багадаа л 65-70% нь зээлтэй, сарын орлогынхоо 50-60%-ийг зээлд төлдөг гэж тооцож болохоор. Айл өрхүүдийн санхүүгийн циклийг ажиглавал намарт хичээл эхлэх болохоор хүүхдүүдийн хичээлийн бэлтгэл хийх гэж зээл авдаг, цагаан сараа хийх гэж нэмж зээлдэг, наадмаар машин лизингддэг ийм л дүр зураг харагдаж байна. Үр дагавар нь хотын гудамжинд багтахгүй түгжрэх олон машин, өрнөөс өрний хооронд ажиллаж амьдрах стресстэй хүмүүс. Одоо тэгээд яах вэ гэж үү? Иргэд бидний хамгийн түрүүнд ямар ч зардалгүйгээр хийж чадах зүйл бол өөрсдөө хандлага, сэтгэлгээгээ өөрчилцгөөе. Тогтолцооны өөрчлөлтийг дараа нь төрөөсөө нэхэцгээе.

Дараах хэдэн зөвлөгөөг өдөр тутмын амьдралдаа дагаж мөрдвөл үр дүн нь удахгүй гарах болно

- Аль болох зээл авахгүйгээр асуудлыг шийдэх гарцыг эрэлхийлэх,
- Богино хугацааны хэрэглээндээ зориулж зээл авахыг хориглох,
- Автомашин, электрон бараа зэрэг хурдан элэгддэг зүйлсийг зээлээр авахаа хязгаарлах,
- Өндөр хүүтэй зээл авах нь маш хурдан өрийн дарамтад оруулдаг гэдгийг анхаарах,
- Зайлшгүй тохиолдолд зээлийн зарцуулалт, өгөөж зэргийг нарийн тооцож сурах.

### **Төгсгөл**

Бидний хөгжлийн жишээ болгож ярих дуртай Герман, Япон зэрэг улсууд 30-40 жилийн дотор Дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэх болсны нууц нь тухайн ард түмний хувь хүний сахилга бат, хариуцлагатай холбоотой гэдгийг бид төвөггүй мэддэг. Үүнтэй адилаар иргэд нь санхүүгийн хувьд хариуцлагатай, сахилга баттай байх нь улс орны хөгжилд чухал нөлөөтэй гэдэг нь тодорхой. Хувь хүний санхүүгийн одоогийн хандлага буюу хэрэглээнд суурилснаас хуримтлалд суурилсан шинэ хандлага руу шилжилт хийх нь туйлын чухал. Тиймээс хүн бүр санхүүгийн шийдвэр гаргалт, санхүүгийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх нь гэр бүл, эх орныхоо өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын нэг юм. Өрх гэр болон хувийн санхүүгээ зөв удирдах, хуримтлалтай байх зэргийг Та бид өөрсдийн амьдралд өдөр тутам хэрэгжүүлээд зогсохгүй, үр хүүхдэдээ зааж сургах үүрэгтэй.

Хуримтлалтай болох нь Хувийн соёл юм шүү гэдгийг ойлгоцгооё, хэрэгжүүлцгээе.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_